

00_Introduction tot he MELINC project

1

Тэгш хамруулах багшийн боловсрол

2

Намайг Грасиене Лауренс гэдэг, Брюсселийн Вриже их сургуулийн багш, бид “Тэгш хамруулах багшийн боловсрол

3

MELINC төслийг Монгол, Польш, Бельги улсын их сургуулиудын консорциумтай хамтран хэрэгжүүлж байна.

4

Боловсролын хүртээмж, тэгш хамруулан сургах боловсролын зарчмыг хэрэгжүүлэхийн тулд бидэнтэй нэгдэхийг та бүхнээс уриалж байна.

5

Эдгээр зарчмуудыг НҮБ -ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенцид тусгасан байдаг.

6

Монгол Улс уг конвенцид нэгдсэн бөгөөд, Монголын хууль тогтоомж энэхүү олон улсын эрх зүйн баримт бичгийг баримталдаг

7

Тусгай хэрэгцээт хүмүүсийн эрхийг боловсролын орчинд хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрч, сурталчлах

8

ёстой бөгөөд учир нь манай нийгэмд бүх хүүхдүүдийн сайн сайхан байдлаас чухал зүйл үгүй.

9

Тэгш хамруулах боловсрол нь тэдний сайн сайхан байдалд хүрэх гол хүчин зүйлүүдийн нэг юм.

10

Бидний зорилго бол Монгол түншүүдтэйгээ хамтран ТХБ-ын модульчилсан хөтөлбөр боловсруулж,

11

өөр өөр зорилтот бүлгүүдэд хүргэх явдал юм.

12

Тусгай хэрэгцээтэй хүмүүс, оюутнуудад боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлүүдийн талаарх түүхэн тоймоос бидний хөтөлбөр эхэлнэ.

13

Дараагийн модулиудад эрх тэгш байдал, хүртээмжтэй орчин,

14

ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчмын талаар суралцах болно.

15

Энэхүү хөтөлбөр нь НҮБ-ын конвенцийн 24 -р зүйл, 4 -р ерөнхий заалтыг таниулах, хэрэгжүүлэх байдлаар үргэлжилнэ.

16

Сургалтын хөтөлбөрөөр “Тэгш хамруулах боловсрол”-ыг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын

17

эрх зүйн бичиг баримт, стратеги төлөвлөлт, нийгмийн хандлага, туршлагаас суралцана.

18

Төслийн хүрээнд тусгай хэрэгцээт сурагчид, тэдний эцэг эх, багш, сургуулиудыг дэмжих

19

"Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдийг дэмжих төв"-ийг Улаанбаатар хот,

20

Ховд, Дорнод аймгуудад байгуулж, техник хэрэгслээр хангаж, сургалтын үйл ажиллагааг явуулах юм.

21

Энэхүү төслийн зорилго нь ТХБ, тусгай хэрэгцээт иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт,

22

тэднийг нийгэмд хүлээн зөвшөөрөх нь гадуурхалт,

23

ядуурлыг зогсоох чухал алхам гэж үзэн Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

24

Илүү хүртээмжтэй чанартай боловсрол бол илүү шударга, ардчилсан нийгмийн орчныг бүрдүүлэхэд чухал.

25

Монгол найз нөхөдтэйгээ нүүр нүүрээ харан уулзаж ярилцах чин хүсэлтэй байгаа хэдий ч,

26

Ковидын цар тахал бидний хамтын ажиллагаанд нөлөөлж байна.

27

Гэсэн хэдий ч бидний гол түнш болох багш нартайгаа, төслийн багийн гишүүдтэйгээ онлайнаар уулзаж, сургалт,

28

хурал бусад арга хэмжээг зохион байгуулах боломжтой байна.

29

Хүн бүрийн боловсролын хэрэгцээг харгалзсан “Тэгш хамруулах боловсрол”-ын

30

үзэл санааг хөгжүүлж, ялгаварлан гадуурхалтаас ангид хүртээмжтэй,

31

чанартай боловсролын төлөө хамтдаа хичээн зүтгэж амжилтад хүрнэ гэдэгт итгэлтэй байна.